



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот


「 Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн  
ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйл, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн түүхт ойн баярыг 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг Удирдан зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ойн баярыг тэмдэглэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, шаардагдах хөрөнгийг нийслэлийн төсөвт тусгаж, нийслэлийн төр захиргааны байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн бүтээлч санал санаачилгыг өрнүүлэн шаардлагатай арга хэмжээ авч, хэрэгжүүлж ажиллахыг Зохион байгуулах хорооны дарга /С.Батболд/-д даалгасугай.


ДАРГА



С.АМАРСАЙХАН

1110100094

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар сарын 23-ны  
өдрийн 29 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 380 ЖИЛИЙН  
ОЙН АРГА ХЭМЖЭЭГ НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын Захирагч;
- Орлогч дарга: Нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан  
төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч;
- Гишүүд: Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын  
хөгжлийн асуудал хариуцсан орлогч;
- Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын  
бохирдлын асуудал хариуцсан орлогч;
- Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал  
хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг  
даргын орлогч;
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчид; /зөвшилцсөнөөр/
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Төлөөлөгчид; /зөвшилцсөнөөр/
- Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд  
Захирагчийн ажлын албаны дарга;
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга;
- Дүүргүүдийн Засаг дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн  
Захиргааны удирдлагын хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн  
Штабын дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн  
сангийн хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
хөгжлийн хэлтсийн дарга;

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга;
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга;
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга;
- Нийслэлийн Замын Цагдаагийн газрын дарга;
- Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга;
- Нийслэлийн Биеийн тамир, спортын хорооны дарга;
- Нийслэлийн Боловсролын газрын дарга;
- Нийслэлийн Соёл урлагийн газрын дарга;
- Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга;
- Нийслэлийн Тээврийн газрын дарга;
- Нийслэлийн Архивын газрын дарга;
- Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дарга;
- Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга;
- Нийслэлийн Улаанбаатар чуулгын дарга;
- Соёлын төв өргөөний захирал;
- Улаанбаатар хотын музейн захирал;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;

Нарийн бичгийн  
дарга:



**НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 380 ЖИЛИЙН ОЙН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
<b>Нэг. Зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар</b>			
1.1	Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн арга хэмжээг Зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах	3 дугаар сарын 23	НЗДТГ
1.2	Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах, тэмдэглэн өнгөрүүлэх салбар хороодын бүрэлдэхүүнийг батлуулах	4 дүгээр сард	Нийгмийн бодлогын хэлтэс
1.3	Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг батлуулах	5 дугаар сард	Нийгмийн бодлогын хэлтэс
1.4	Ой угтсан ажил, тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах нэгдсэн төсвийг нэгтгэн батлуулах	5 дугаар сард	Санхүү, төрийн сангийн хэлтэс
1.5	Дүүрэг бүр өөрсдийн нутаг дэвсгэрт ойг угтаж нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах хороог байгуулах, төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах	Жилдээ	Дүүргийн Засаг дарга нар
1.6	Нийслэлийн төр захиргааны байгууллагууд ойг зохион байгуулах ажлын хүрээнд төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах	Жилдээ	Харъяа газрын дарга нар
1.7	Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн медаль гаргах	8 дугаар сард	НЗДТГ
1.8	Гадаад дотоодын төлөөлөгчдөд урилга хүргүүлэх	4 дүгээр сард	Гадаад харилцааны хэлтэс
1.9	Гадаад дотоодын төлөөлөгчдөд өгөх бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх	7 дугаар сард	НЗДТГ
1.10	Урилга хэвлүүлэх	9 дүгээр сард	Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
<b>Хоёр. Тохижилтын ажлын талаар</b>			
2.1	“380 жил” гэсэн цэцгэн байгууламжийг төв гудамж, талбайд байрлуулах	6 дугаар сард	Улаанбаатар хотын ЗАА
2.2	Ойг угтаж гэр хорооллын хашаандаа мод сөөг тарьж ургуулсан айл өрхүүдийг урамшуулах ажлыг зохион байгуулах	10 дугаар сард	Улаанбаатар хотын ЗАА

2.3	“Хоггүй гудамж- хоггүй хороо” болзолт уралдааныг дүгнэх	9 дүгээр сар	Улаанбаатар хотын 3АА
2.4	Шилдэг тохижилттой байгууллага аж ахуйн нэгж шалгаруулах	9 дүгээр сар	Улаанбаатар хотын 3АА
2.5	Гудамж, зам талбайн ногоон байгууламжийн арчилгаа, цэцэгжүүлэлт сайн хийсэн иргэн, аж ахуйн нэгжийг шалгаруулах	9 дүгээр сар	Улаанбаатар хотын 3АА
2.6	“Шилдэг тохижилттой Дүүрэг” уралдаан зарлаж, шалгаруулах	5-10 дугаар сард	Улаанбаатар хотын 3АА
2.7	“Тохилог гудамж” гэр хорооллын цэвэр, тохижилт сайтай гудамж, хөршийн холбоог шалгаруулах	9 дүгээр сар	Улаанбаатар хотын 3АА
2.8	“Их хотын хямдрал-380” хямдралтай, урамшуулалтай өргөтгөсөн үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	10 дугаар сарын 22-29	Улаанбаатар хотын 3АА
2.9	Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна хаягжилтыг сайжруулж, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	5-10 дугаар сард	Улаанбаатар хотын 3АА
2.10	Ойг угтаж гудамж замын тэмдгийг угаах, зорчих хэсгийн тэмдэглэлийг сэргээн будах, замын гэрэлтүүлгийн бүрэн бүтэн байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах	4 дүгээр сарын 10	Улаанбаатар хотын 3АА
2.11	Д.Сүхбаатарын талбайн ойр орчмын аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна гэрэлтүүлгийг асаах	10 дугаар сарын 20-ноос 29	Улаанбаатар хотын 3АА
2.12	Ойн арга хэмжээг угтаж бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах	Улиралд 1 удаа	Улаанбаатар хотын 3АА
<b>Гурав. Соёл урлаг, спортын ажлын талаар</b>			
3.1	“Улаанбаатарын намар” арга хэмжээ зохион байгуулах	10 дугаар сард	Нийгмийн бодлогын хэлтэс Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс Нийслэлийн Соёл, урлагийн газар
3.2	“Хүүхдийн найрал дуу”-ны наадам /2 үе шаттай/	10 дугаар сарын 29	Нийслэлийн Соёл урлагийн газар Нийслэлийн Боловсролын газар Соёлын төв өргөө
3.3	“Их хотын бүсгүйчүүд” арга хэмжээ зохион байгуулах	3 дугаар сард	Нийгмийн бодлогын хэлтэс
3.4	Нийслэлийн түүхэнд холбогдох архивын нэн үнэт болон гэрэл зургийн баримтаар үзэсгэлэн гаргах	9 дүгээр сар	Нийслэлийн Архивын газар
3.5	Улаанбаатар хотын үеийн түүхийг харуулсан гэрэл зургийн явуулын самбар хийж, аж ахуйн нэгж байгууллага, нийтийн гудамж талбайд үзэсгэлэн гаргах	9-10 дугаар сард	Нийслэлийн Соёл урлагийн газар Улаанбаатар хотын музей



3.6	Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойд зориулсан Үндэсний бөхийн барилдаан	10 дугаар сарын 28	Цэргийн штаб Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо
3.7	“Улаанбаатар марафон” олон улсын гүйлтийн тэмцээн зохион байгуулах	6 дугаар сард	Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо
3.8	“UB SPORT-2019” биеийн тамир, спортын өдөрлөг зохион байгуулах	10 дугаар сард	Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо
3.9	Ойг угтаж нийслэлийн төр захиргааны байгууллагуудын дунд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын байгууллагын нэрэмжит сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах	6 дугаар сард	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
3.10	Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Нийслэл өргөө” дартсын тэмцээн зохион байгуулах	10 дугаар сард	НЗДТГ
3.11	ЕБС-ийн сурагчдын дунд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Их нүүдэл” шатрын тэмцээн зохион байгуулах	9 дүгээр сард	Нийслэлийн Боловсролын газар
3.12	ЕБС-ийн сурагчдыг -ТЭЦ - УБ Дулааны сүлжээ ХК -Цахилгаан тээвэр компани -УСУГ-ын сургалтын төвийн ус сурталчилгааны танхим -Замын хөдөлгөөний удирдлагын төв зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулах	9 дүгээр сард	Нийслэлийн Аялал жуулчлалын газар Нийслэлийн Боловсролын газар Нийслэлийн Тээврийн газар
	Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд болзолт уралдаан зарлах, дүгнэх	9-10 дугаар сард	Нийслэлийн Тээврийн газар
3.13	Нийслэлийн ЕБС-иудын ахлах ангийн сурагчдын дунд “Өсвөрийн аврагч-2019” тэмцээн зохион байгуулах	10 дугаар сард	Нийслэлийн Онцгой байдлын газар
3.14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын тэмцээн зохион байгуулах	5 дугаар сард	Нийгмийн бодлогын хэлтэс
<b>Дөрөв. Ёслолын арга хэмжээний талаар</b>			
4.1	380 жилийн ойн хүрээнд ах дүү, найрамдалт хотуудын төлөөлөгчдийг хүлээж авах	7-10 дугаар сард	Гадаад харилцааны хэлтэс
4.2	Улаанбаатар хотод байгаа дипломат төлөөлөгчийн газар, ОУ-ын байгууллагын тэргүүн нарт зориулан НЗД-аас барих хүндэтгэлийн хүлээн авалт	8 дугаар сард	Гадаад харилцааны хэлтэс
4.3	Нийслэлийн удирдлагаар ажиллаж байсан хүмүүст хүндэтгэл үзүүлэх	10 дугаар сард	НЗДТГ

4.4	Улаанбаатар хотын анхны үүслийн өлгий нутаг Ширээт цагаан нуурын хөвөөн дэх Гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх	10 дугаар сард	Цэргийн штаб Нийгмийн бодлогын хэлтэс
4.5	Нийслэлийн анхны шав тавьсан "Мэлхийт" хөшөөнд хүндэтгэл үзүүлж, Нийслэлийн сүлдэт хуур цэнгүүлэх ёслол	10 дугаар сарын 29	Нийгмийн бодлогын хэлтэс Нийслэлийн Соёл урлагийн газар
4.6	Нийслэлийн туг мандуулах ёслол хүндэтгэлийн ажиллагаа	10 дугаар сарын 29	Цэргийн штаб
4.7	Улаанбаатар цэргийн хүрээний анги байгууллагад Нийслэлийн тугийг мандуулах	10 дугаар сарын 29	Цэргийн штаб Дүүргүүдийн цэргийн штаб
4.8	Нийслэлийн шилдэг бүтээн байгуулалтыг шалгаруулах, шагнах ёслолын ажиллагаа	10 дугаар сарын 28	Бодлого, төлөвлөлтийн хэлтэс
4.9	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын тэргүүний ажилтнууд, иргэдэд шагнал гардуулах ажиллагаа	10 дугаар сарын 28	НИТХ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
4.10	2017 оны нийслэлийн Шилдэг хороо, Хэсгийн ахлагч нарын шилдэг баг шалгаруулах болзолт уралдааны шагнал гардуулах	10 дугаар сарын 20	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
4.11	"Тэргүүний өрх, гэр"-ийг шагнах ажиллагаа	10 дугаар сарын 28	Нийгмийн бодлогын хэлтэс Нийслэлийн Ахмадын хороо
4.12	Хүндэт донор иргэдэд хүндэтгэл үзүүлэх	10 дугаар сарын 29	НЗДТГ
4.13	Эрүүл мэндийг дэмжигч өрх, иргэн шалгаруулах, шагнах	10 дугаар сарын 25	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
<b>Тав. Хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны талаар</b>			
5.1	Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн бүхий л арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллах	Жилдээ	Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
5.2	"Улаанбаатар-380" цуврал нэвтрүүлэг хийх	Жилдээ	Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
5.3	Нийслэл хотын бүтээн байгуулалт, тэргүүний дүүрэг, хороо, багш, эмчийн талаарх хөтөлбөр бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах	10 дугаар сарын 29	Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
5.4	Ойд зориулсан баримтат кино бүтээх, цацах /40-45 минут/	10 дугаар сард бэлэн болгох	Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
5.5	"Иргэнээ дээдэлсэн Улаанбаатар" /Хотын даргын нэг жилийн ажлын тайлан/	10 дугаар сарын 29	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
5.6	ЕБС-иудад нийслэлийн удирдлагууд хичээл заах	10 дугаар сарын 29	Нийслэлийн боловсролын газар



5.7	Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойд зориулан Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах	9 дүгээр сард	Нийслэлийн Архивын газар
5.8	“Мөрөөдлийн хот” гар зургийн уралдаан зарлаж, үзэсгэлэн зохион байгуулах	5 дугаар сард	Монголын Хүүхдийн урлан бүтээх төв